

БАТЛАВ. ТУЗ-ИЙН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ

НОГДОЛ АШГИЙН ЖУРАМ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү ногдол ашгийн журам (цаашид “Журам” гэх) нь Тандэм Инвэст ББСБ ХК (цаашид “Компани” гэх)-ийн ногдол ашгийн бодлогын баримт бичиг бөгөөд ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргах, хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, олгох, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2 Энэхүү журмыг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн дүрэм болон зохицуулах байгууллагаас гаргасан бусад дүрэм журмын хүрээнд Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-өөс баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

Хоёр. НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

- 2.1. Компанийн ногдол ашгийн бодлого нь Компанийн үйл ажиллагаа болон стратегийн бодлоготой уялдсан байна.
- 2.2. Компани хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийг зүй зохистой захиран зарцуулж, ногдол ашгийн хэмжээг зохистой түвшинд байлгах бодлоготой ажиллана.
- 2.3. Компани нь Компанийн тухай хуулийн 47-р зүйл, Компанийн дүрмийн 12.3-д заасан ногдол ашиг хуваарилах нөхцөл хангагдсан тохиолдолд ногдол ашиг хуваарилна.
- 2.4. Нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг тухайн санхүүгийн жилийн татварын дараах цэвэр ашгийн хэмжээ, Компанийн богино болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага зэргийг үндэслэн ТУЗ тогтооно.
- 2.5. Тухайн санхүүгийн жилд олсон цэвэр ашиг нь өмнөх жилийнхээс буураагүй тохиолдолд ногдол ашгийн хэмжээг бууруулахгүй байх бодлого баримтална.
- 2.6. Ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр олгоно.
- 2.7. Ногдол ашиг хуваарилсны дараа үлдэх ашгаас нийгэм, соёлын арга хэмжээ, үйлдвэр хөгжүүлэх сан байгуулж болно. Санг байгуулах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ.

Гурав. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ШИЙДВЭР ГАРГАХ, ОЛГОХ

- 3.1 Компанийн ТУЗ нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 3.2 ТУЗ нь тухайн жилд ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай үндэслэлээ хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнана.
- 3.3 Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрт дараах зүйлсийг тусгасан байна:

- 3.3.1 Хувьцааны төрөл тус бүрээр нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ

- 3.3.2 Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр
- 3.3.3 Ногдол ашиг олгож эхлэх, дуусах хугацаа
- 3.3.4 Ногдол ашгийг олгох арга зам, хэлбэр
- 3.4 Компани хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг өөрийн байранд бэлэн мөнгөөр тараах болон Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвөөр дамжуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүлэх аргын алиныг ч хэрэглэж болно.
- 3.5 Хувьцаа эзэмшигч нь арилжааны банкин дахь өөрийн харилцах болон хадгаламжийн дансанд ногдол ашгийг шилжүүлж авах талаар бичгээр хүсэлт гаргаж, холбогдох мэдээллийг өгсөн тохиолдолд ногдол ашгийг хувьцаа эзэмшигчийн дансанд шилжүүлж болно.

Дөрөв. МЭДЭЭЛЭХ, ТАЙЛАГНАХ

- 4.1 Компани ногдол ашиг хуваарилахтай холбоотой мэдээллийг хувьцаа эзэмшигчдийн хурлын зар мэдээг хүргэдэг журмаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хувьцаа эзэмшигчдэд хүргэхээс гадна ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар дамжуулан саадгүй танилцах боломжийг бүрдүүлнэ.
- 4.2 Ногдол ашиг хуваарилалтын тайланг холбогдох журмын дагуу гарган, Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлэхээс гадна хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд заавал тайлагнана.

Тав. ХАРИУЦЛАГА

- 5.1 Компани ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бол уг шийдвэрт заасан хугацаанд ногдол ашгийг бүрэн олгож дуусгана.
- 5.2 Ногдол ашгийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд Компанийн тухай хууль болон холбогдох хууль, дүрэм журамд заасны дагуу хариуцлага хүлээнэ.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ